

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/28 НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2024.02.22

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор : Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Долгорсүрэн
Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Ахлах аудитор: О.Баярмаа
Утас: 261628 Цахим хаяг: bayarmaa@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Баян ташаагийн эх аудит
ХХК-ийн захирал Т.Хоролсүрэн
Утас: 99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.29 № 04/518

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 68,450.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс 59,194.8 мянган төгрөгөөр их байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй, оршин байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийгмийн эрүүл мэндийн төв баталсан 2023 оны үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 14,452.5 мянган төгрөгөөр тасалсан нь ковидын шинжилгээ өмнөх оноос 96.2 хувиар буурсантай холбоотой байна.

Аудитын гол асуудал

Олон нийтийн цахим сүлжээ буюу Улс төрч.мн сайтад 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр тавигдсан мэдээлэлд дурдсан “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах ,чиг хандлага үндэсний чуулган”-д 21 аймаг, 9 дүүргээс оролцсон 50 төлөөлөгч нарт олгох 42,120.0 мянган төгрөгийн зардлыг нэгдсэн журмаар Чингис хаан зочид буудлын дансанд шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Тухайлбал, Үйлдвэрийн чанарын лабораторийн үйл ажиллагааг MNS/ISO/IEC 17025:2017 стандарт хүрээ болон Эрдмийн зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлуулж, журмын дагуу үйл ажиллагаа явуулах гэсэн 2 арга хэмжээний гүйцэтгэл зорилтот түвшинд хүрсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|--|--------------------|--------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,750,393,193.85 | 587,671,323.64 |
| 33 | АВЛАГА | 894,939,181.24 | 401,472,518.04 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 1,703,018.12 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 889,121,062.12 | 399,769,499.92 |
| 335 | Бусад авлага | 5,818,119.12 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 5,818,119.12 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 855,454,012.61 | 186,198,805.60 |
| 351 | Түүхий эд материал | 840,907,536.85 | 139,508,016.62 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 49,933,914.05 | 7,881,464.82 |
| 35130 | Эм боох материал | 790,973,622.80 | 31,626,551.80 |
| 354 | Хангамжийн материал | 14,546,475.76 | 46,690,788.98 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,292,128.66 | 5,410,779.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,145,175.90 | 6,800,725.00 |
| 35440 | Түлц, шатах тослох материал | 302,750.00 | 10,060,600.00 |
| 35450 | Барилгын засварын материал | - | 3,182,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 9,806,421.20 | 21,236,684.98 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,281,538,690.28 | 2,200,225,465.35 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,281,538,690.28 | 2,200,225,465.35 |
| 392 | Биет хөрөнгө | 1,967,701,368.68 | 1,886,388,143.75 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 410,605,737.00 | 410,605,737.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (118,960,102.08) | (148,025,127.60) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 37,900,000.00 | 37,900,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (5,053,333.28) | 8,843,333.24 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 3,095,301,973.81 | 3,298,558,773.81 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,519,766,050.60) | (1,767,426,099.91) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 107,010,249.00 | 120,610,249.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (59,428,847.42) | (76,166,522.60) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 18,925,475.00 | 29,372,300.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (15,033,399.96) | (26,397,499.92) |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 10,446,825.00 | - |
| 39212 | Хуримтлагдсан элэгдэл | (10,446,825.00) | - |
| 39217 | Ном | 16,199,667.21 | 16,199,667.21 |
| 393 | Биет бус хөрөнгө | 313,837,321.60 | 313,837,321.60 |
| 39301 | Программ хангамж | 2,473,000.00 | 2,473,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,473,000.00) | (2,473,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 313,837,321.60 | 313,837,321.60 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 4,031,931,884.13 | 2,787,896,788.99 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 2,230,580.09 | 101,794,390.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2,230,580.09 | 101,794,390.00 |
| 413 | Өглөг | 2,230,580.09 | 101,794,390.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 397,580.09 | - |
| 4136 | Бусад өглөг | 1,833,000.00 | 101,794,390.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,833,000.00 | 101,794,390.00 |

| | | | |
|-------|---|------------------|--------------------|
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,029,701,304.04 | 2,686,102,398.99 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 4,029,701,304.04 | 2,686,102,398.99 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,715,526,272.67 | 2,715,526,272.67 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 883,942,040.15 | (459,656,864.90) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 883,942,040.15 | 883,942,040.15 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (1,343,598,905.05) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 430,232,991.22 | 430,232,991.22 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 4,031,931,884.13 | 2,787,896,788.99 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон / төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|---------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 6,845,053,214.32 | 6,080,393,923.62 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,218,052,563.20 | 262,587,718.28 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,218,052,563.20 | 262,587,718.28 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 202,590,593.00 | 27,088,048.28 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 202,590,593.00 | 27,088,048.28 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 212,131,900.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 1,015,461,970.20 | 23,367,770.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 5,627,000,651.12 | 5,817,806,205.34 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,890,717,100.00 | 2,920,110,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,890,717,100.00 | 2,920,110,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,927,709,063.80 | 2,897,696,005.34 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,360,343,311.80 | 2,540,441,031.04 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 567,365,752.00 | 313,117,706.30 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 44,137,268.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 287,562,987.32 | - |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 287,562,987.32 | - |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 521,011,500.00 | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 521,011,500.00 | - |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 6,798,649,382.49 | 7,423,992,828.67 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 6,798,649,382.49 | 7,423,992,828.67 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 6,567,008,448.48 | 7,068,331,528.69 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,576,057,752.05 | 2,841,606,706.28 |
| 210101 | Үндсэн цалин | 1,803,278,223.45 | 1,967,784,313.05 |
| 210102 | Нэмэгдэл | 504,044,346.74 | 537,904,342.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 121,085,441.24 | 107,881,730.86 |
| 210104 | Урамшуулал | 147,649,740.62 | 228,036,320.27 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 334,620,987.80 | 375,463,835.45 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 252,400,438.40 | 246,145,682.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 21,753,126.17 | 29,745,322.44 |

| | | | |
|--------|--|------------------|--------------------|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 16,627,308.85 | 29,360,047.72 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,954,669.83 | 5,185,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 39,885,444.55 | 65,027,382.40 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 81,620,220.03 | 97,335,385.16 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 45,504,368.19 | 57,219,901.04 |
| 210302 | Түлш, халаалт | 26,142,844.84 | 25,823,529.12 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,973,007.00 | 8,611,955.00 |
| 210304 | Байрны түрээс | - | 5,680,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,188,953,464.31 | 1,014,370,076.82 |
| 210401 | Бичиг хэрэг | 83,518,517.00 | 85,756,421.66 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 139,813,665.25 | 209,638,761.75 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 27,488,712.70 | 122,094,468.06 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 9,494,360.00 | 3,502,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 928,638,209.36 | 37,206,956.50 |
| 210408 | Бараа материал ақталсны зардал | - | 556,171,068.85 |
| 2105 | Нормативт зардал | 1,231,648,672.65 | 366,563,011.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,229,771,672.65 | 338,786,651.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 23,876,360.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,877,000.00 | 3,900,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,606,596.00 | 38,784,340.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500,000.00 | 297,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 839,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,106,596.00 | 37,647,540.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 155,618,951.80 | 507,416,810.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 7,712,565.80 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 147,906,386.00 | 507,416,810.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 443,999,209.07 | 1,200,593,776.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 439,573,549.07 | 1,196,997,615.80 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,000,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 59,400.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 885,170.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 32,300.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,311,260.00 | 2,678,691.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 544,882,594.77 | 626,197,587.18 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,660,000.00 | 34,178,197.25 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 204,429,123.80 | 293,849,365.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 313,793,470.97 | 298,170,024.93 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 231,640,934.01 | 355,661,299.98 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 33,577,977.00 | 130,527,905.30 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 28,877,977.00 | 128,077,905.30 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,700,000.00 | 2,450,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 198,062,957.01 | 225,133,394.68 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 198,062,957.01 | 37,662,196.64 |
| 213305 | Хөрөнгийн | | 187,471,198.04 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 46,403,831.83 | (1,343,598,905.05) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 46,403,831.83 | (1,343,598,905.0) |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|--------------------|--|
| C01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,715,526,272.67 | 30,232,991.22 | 837,548,208.32 | 3,983,307,472.21 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,715,526,272.67 | 430,232,991.22 | 837,548,208.32 | 3,983,307,472.21 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 67,695,648.86 | 67,695,648.86 |
| C08 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,715,526,272.67 | 430,232,991.22 | 905,243,857.18 | 4,051,003,121.07 |
| D01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 2,715,526,272.67 | 430,232,991.22 | 905,243,857.18 | 4,051,003,121.07 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (21,301,817.03) | (21,301,817.03) |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,715,526,272.67 | 430,232,991.22 | 883,942,040.15 | 4,029,701,304.04 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (1,343,598,905.05) | (1,343,598,905.05) |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,715,526,272.67 | 430,232,991.22 | (459,656,864.90) | 2,686,102,398.99 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|-------------------------|-------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 6,313,059,603.51 | 6,735,304,715.74 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 202,590,593.00 | 35,547,548.28 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 202,590,593.00 | 35,547,548.28 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 202,590,593.00 | 35,547,548.28 |
| 120004 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 202,590,593.00 | 35,547,548.28 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 6,110,469,010.51 | 6,699,757,167.46 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,890,717,100.00 | 2,920,110,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,890,717,100.00 | 2,920,110,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,352,829,866.19 | 3,779,646,967.46 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,785,464,114.19 | 3,429,562,093.16 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 567,365,752.00 | 313,117,706.30 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 36,967,168.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 345,910,544.32 | - |

| | | | |
|--------|--|------------------|------------------|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 345,910,544.32 | - |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 521,011,500.00 | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 521,011,500.00 | - |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 6,282,936,803.51 | 6,730,579,815.74 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 6,282,936,803.51 | 6,730,579,815.74 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 5,162,174,807.38 | 5,975,149,015.84 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,576,607,639.94 | 2,839,976,511.03 |
| 210101 | Үндсэн цалин | 1,807,959,249.67 | 1,930,518,774.47 |
| 210102 | Нэмэгдэл | 475,566,627.62 | 573,539,685.43 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 121,130,651.40 | 118,095,651.13 |
| 210104 | Урамшуулал | 171,951,111.25 | 217,822,400.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 332,893,819.35 | 375,977,935.54 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 250,781,789.80 | 247,554,132.98 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 21,725,996.22 | 32,662,808.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 16,605,604.85 | 25,476,211.96 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,949,243.84 | 5,185,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 39,831,184.64 | 65,099,382.40 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 84,767,637.03 | 126,925,385.16 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 45,504,368.19 | 57,219,901.04 |
| 210302 | Түлш, халаалт | 27,475,761.84 | 25,823,529.12 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,787,507.00 | 8,611,955.00 |
| 210304 | Байрны түрээс | - | 35,270,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 314,281,568.48 | 438,436,219.06 |
| 210401 | Бичиг хэрэг | 94,871,838.25 | 82,968,271.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 134,067,981.00 | 211,615,676.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 27,518,712.70 | 121,323,468.06 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,319,360.00 | 3,952,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 47,503,676.53 | 18,576,404.00 |
| 2105 | Нормативт зардал | 810,438,077.27 | 119,110,970.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 781,639,877.27 | 114,346,810.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 864,160.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 28,798,200.00 | 3,900,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 45,744,759.60 | 42,225,940.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,219,480.00 | 297,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 506,000.00 | 839,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 37,019,279.60 | 41,089,140.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 168,474,520.84 | 492,252,820.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 13,353,874.84 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 155,120,646.00 | 492,252,820.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 505,142,209.07 | 1,124,366,146.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 500,716,549.07 | 1,118,688,249.80 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,000,000.00 | 4,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 59,400.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 140,111.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 32,300.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,311,260.00 | 1,505,486.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 323,824,575.80 | 415,877,088.25 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 39,660,000.00 | 36,553,597.25 |

| | | | |
|--------|---|------------------|----------------|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 284,164,575.80 | 379,323,491.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,120,761,996.13 | 755,430,799.90 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 33,577,977.00 | 130,527,905.30 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 28,877,977.00 | 128,077,905.30 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,700,000.00 | 2,450,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 198,062,957.01 | 624,902,894.60 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 198,062,957.01 | 37,662,196.64 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 587,240,697.96 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 889,121,062.12 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 889,121,062.12 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 30,122,800.00 | 4,724,900.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 30,122,800.00 | 4,724,900.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 30,122,800.00 | 4,724,900.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 30,122,800.00 | 4,724,900.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 30,122,800.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 4,724,900.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | 30,122,800.00 | 4,724,900.00 |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | | |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--|-----------------|-----------------|----------------|-------|
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,970,110,200.0 | 2,917,995,551.6 | 52,114,648.4 | 99.9 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 2,970,110,200.0 | 2,917,995,551.6 | 52,114,648.4 | 98.2 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,839,352,100.0 | 2,787,467,646.3 | 51,884,453.7 | 98.2 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,228,610,900.0 | 2,228,171,285.5 | 439,614.5 | 99.9 |
| Үндсэн цалин | 1,364,914,700.0 | 1,318,713,548.9 | 46,201,151.1 | 96.6 |
| Нэмэгдэл | 488,573,800.0 | 573,539,685.4 | (84,965,885.4) | 117.3 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 157,300,000.0 | 118,095,651.1 | 39,204,348.9 | 75.0 |
| Урамшуулал | 217,822,400.0 | 217,822,400.0 | - | 100.0 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 322,948,800.0 | 291,178,128.4 | 31,770,671.6 | 90.1 |
| Тэтгэврийн даатгал | 220,184,400.0 | 188,413,728.4 | 31,770,671.6 | 85.5 |
| Тэтгэмжийн даатгал | 25,691,100.0 | 25,691,100.0 | - | 100.0 |
| ҮОМШӨ-ний даатгал | 20,552,900.0 | 20,552,900.0 | - | 100.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 5,138,200.0 | 5,138,200.0 | - | 100.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 51,382,200.0 | 51,382,200.0 | - | 100.0 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 92,227,000.0 | 91,655,385.2 | 571,614.8 | 99.4 |
| Гэрэл, цахилгаан | 57,237,200.0 | 57,219,901.0 | 17,299.0 | 99.9 |
| Түлш, халаалт | 26,377,800.0 | 25,823,529.1 | 554,270.9 | 97.9 |
| Цэвэр, бохир ус | 8,612,000.0 | 8,611,955.0 | 45.0 | 100.0 |
| Хангамж, бараа материалын зардал | 32,442,700.0 | 30,622,583.1 | 1,820,116.9 | 94.4 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,305,300.0 | 6,305,333.1 | (33.1) | 100.0 |

| | | | | |
|---|------------------------|-------------------------|------------------------|--------------|
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,772,600.0 | 3,952,400.0 | 1,820,200.0 | 68.5 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,419,300.0 | 11,419,300.0 | - | 100.0 |
| Нормативт зардал | 98,351,200.0 | 82,188,630.0 | 16,162,570.0 | 83.6 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 94,451,200.0 | 78,288,630.0 | 16,162,570.0 | 82.9 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,900,000.0 | 3,900,000.0 | - | 100.0 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 29,142,400.0 | 29,142,140.0 | 260.0 | 100.0 |
| Урсгал засвар | 29,142,400.0 | 29,142,140.0 | 260.0 | 100.0 |
| Томилолт, зочны зардал | 1,278,000.0 | 1,278,000.0 | - | 100.0 |
| Дотоод албан томилолт | 1,278,000.0 | 1,278,000.0 | - | 100.0 |
| Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамж | | 5,677,897.0 | 564,103.0 | 90.9 |
| Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 4,000,000.0 | - | 100.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 140,200.0 | 140,111.0 | 89.0 | 99.9 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 102,300.0 | 32,300.0 | 70,000.0 | 31.5 |
| Газрын төлбөр | 1,999,500.0 | 1,505,486.0 | 494,014.0 | 75.2 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 28,109,100.0 | 27,553,597.3 | 555,502.8 | 98.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 28,109,100.0 | 27,553,597.3 | 555,502.8 | 98.0 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 130,758,100.0 | 130,527,905.3 | 230,194.7 | 99.8 |
| Бусад урсгал шилжүүлэг | 130,758,100.0 | 130,527,905.3 | 230,194.7 | 99.8 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 128,078,000.0 | 128,077,905.3 | 94.7 | 100.0 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,680,100.0 | 2,450,000.0 | 230,100.0 | 91.4 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,970,110,200.0 | 2,955,657,748.30 | 14,452,451.70 | 99.5 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,920,110,200.0 | 2,920,110,200.0 | - | 100.0 |
| Улсын төсвөөс санхүүжих | 2,920,110,200.0 | 2,920,110,200.0 | - | 100.0 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 50,000,000.0 | 35,547,548.3 | (14,452,451.70) | 71.1 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 50,000,000.0 | 35,547,548.3 | (14,452,451.70) | 71.1 |
| АЖИЛЛАГСДЫН ТОО | 130 | 102 | 28 | 78.5 |
| Удирдах ажилтан | 1 | 1 | 0 | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 101 | 73 | 28 | 72.3 |
| Үйлчлэх ажилтан | 28 | 28 | 0 | 100.0 |
| Гэрээт ажилтан | - | 12 | 12 | 100.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|------------|--|------------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,192,406,269.50 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,192,406,269.50 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,192,406,269.50 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 611,805,225.53 |
| 210101 | Үндсэн цалин | 611,805,225.53 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 84,799,807.17 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,140,404.61 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,971,708.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,923,311.96 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 47,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,717,182.40 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 35,270,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 35,270,000.00 |

| | | |
|--------|--|------------------|
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 407,813,636.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 74,022,721.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 211,615,676.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 115,018,135.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,157,104.00 |
| 2105 | Нормативт зардал | 36,922,340.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 36,058,180.00 |
| 210502 | Хоол, хүнс | 864,160.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 17,808,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,021,900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 839,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,947,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 490,974,820.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 490,974,820.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,118,688,249.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,118,688,249.80 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 388,323,491.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 379,323,491.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,779,646,967.46 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,779,646,967.46 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,429,562,093.16 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 313,117,706.30 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 36,967,168.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 87,113.0 мянган төгрөгийн 3 алдаа илрүүлж, аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 127,645.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 1,818.9 мянган төгрөгийн зөрчлийг төлүүлэхээр 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 82,717.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 43,108.9 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 127,645.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 68,450.4 мянган төгрөгөөс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

Төлбөрийн акт

Үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн сургалт, судалгааны ажлыг гүйцэтгэсэн нэр бүхий 42 албан хаагчид 1,818.9 мянган төгрөгийн урамшууллыг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдад илүү тооцож олгосон урамшууллыг холбогдох албан тушаалтнаар төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоов.

Албан шаардлага

Төсөл, хөтөлбөрийн сургалт, судалгааны 390 хүнд 672,513.6 мянган төгрөгийн урамшууллыг 390 хүнд олгохдоо ажил олгогчийн төлөх 12.3 хувийн нийгмийн даатгалын шимтгэлийн 82,717.4 мянган төгрөгийг хувь хүнээс суутгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй, оршин байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөл, хөтөлбөрийн сургалт, судалгааны урамшууллыг олгохдоо ажил олгогчийн төлөх 12.3 хувийн нийгмийн даатгалын шимтгэлийг хувь хүнээс суутгасан зөрчлийг арилгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Нэр бүхий 10 ажилтанд олгосон 43,108.9 мянган төгрөгийн ажлын хөлс, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийг худалдан авалтаар татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд шивж, илгээсэн байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажлын хөлс, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийг худалдан авалтаар татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд шивж, илгээсэн зөрчлийг холбогдох эрх бүхий байгууллагад хандан засуулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 898,259.6 мянган төгрөгийн 30 гүйлгээ, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим системд мэдээллийг хуульд заасан хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлээгүй зөрчлийг арилгах, өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах талаар албан шаардлага хүргүүлэв.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|------------|-----------------|-----------------------------------|-----|--------------------------|-----------------|------------|-----------------|-------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Тайлант онд үндсэн хөрөнгийн 76,666.2 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тайланд зөрүүтэй тусгасан, | 1 | 76,666.2 | | | 1 | 76,666.2 | 1 | 76,666.2 | | | | |
| Тайлант онд 6 нэр төрлийн 10,446.8 мянган төгрөгийн зам гүүр, байгууламжийн дансанд бүртгэх үндсэн хөрөнгийг батлан хамгаалахын цэргийн зориулалттай тоног төхөөрөмж дансанд бүртгэсэн, | 1 | 10,448.8 | | | 1 | 10,448.8 | 1 | 10,448.8 | | | | |
| Тайлант онд үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд 3 ААН-тэй байгуулсан 9,783.6 мянган төгрөгийн худалдан авах гэрээг дүгнэж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | 1 | 9,783.6 | | | 1 | 9,783.6 | 1 | 9,783.6 | | | | |
| Дүн | 3 | 87,113.0 | | | 3 | 87,113.0 | 3 | 87,113.0 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|----------|---------------|---------|-----------------|----------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Нэр бүхий 42 хүнд 1,818.9 мянган төгрөгийн төсөл хөтөлбөрийн сургалт, судалгааны ажлын хөлсийг илүү олгосон. | 1 | 1,818.9 | 1 | 1,818.9 | | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн хүрээнд 67 төсөл хөтөлбөрийн зардлаас 390 хүнд нийт 672,513.6 мянган төгрөгийн сургалт, судалгааны ажлын хөлсийг олгож, ажил олгогчийн нийгмийн даатгалын 82,717.4 | 1 | 82,717.4 | | | 1 | 82,717.4 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|-----------|---|---------|---|----------|---|----------|--|--|--|--|
| мянган төгрөгийн шимтгэлийг хувь хүнээс суутгасан. | | | | | | | | | | | | |
| Нэр бүхий 10 ажилтанд олгосон 43,108.9 мянган төгрөгийн ажлын хөлс, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийг худалдан авалтаар шивсэн байна. | 1 | 43,108.9 | | | | | 1 | 43,108.9 | | | | |
| Дүн | 3 | 127,645.2 | 1 | 1,818.9 | 1 | 82,717.4 | 1 | 43,108.9 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|--|-------------|-----------|-----------------|-----------|---------|-----|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| <i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i> | | | | | | |
| Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 898,259.6 мянган төгрөгийн 30 мэдээллийг байршуулаагүй байна. | 1 | 898,259.6 | 1 | 898,259.6 | | |
| Дүн | 1 | 898,259.6 | 1 | 898,259.6 | | |